



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 480

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.3, 3.4 дэх заалт, Сангийн сайдын 2019 оны 74, 111 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шинжлэх Ухааны Академийн Палеонтологийн хүрээлэнгийн албан хэрэгцээнд зориулан 172,490,000.00 (нэг зуун далан хоёр сая дөрвөн зуун ерэн мянган) төгрөгт багтаан үндсэн хөрөнгө олж авахыг зөвшөөрч, худалдан авах үнийн дээд хязгаар, автомашины техникийн үзүүлэлтийг хавсралтаар тогтоосугай.

2.Шинжлэх Ухааны Академийн ерөнхийлөгч Д.Рэгдэл, Палеонтологийн хүрээлэнгийн захирал Х.Цогтбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА


З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 11 дүгээр сарын 13 ны өдрийн
...480... дугаар тогтоолын хавсралт



Шинжлэх ухааны Академийн Палеонтологийн хүрээлэнгийн
олж авах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр, автомашины техникийн үзүүлэлт	Хэмж их нэгж	Тоо хэмж ээ	Нэг бүрийн үнэ	Худалдан авах үнийн дээд хязгаар
				(төгрөг)	
1	Суудлын автомашин (6 хүний суудалтай, хөдөлгүүрийн багтаамж 4000 cc хүртэл ,шинэ)	ш	1	123,000,000.00	123,000,000.00
2	Цахилгаан үүсгүүр /мотор/	ш	1	1,650,000.00	1,650,000.00
3	Лабораторийн татах шүүгээ	ш	1	4,800,000.00	4,800,000.00
4	Лабораторийн мотор	ш	1	400,000.00	400,000.00
5	Дээжинд зориулсан сав	ш	150	25,000.00	3,750,000.00
7	Нураагч /молдок/	ш	1	1,760,000.00	1,760,000.00
10	Лабораторийн багаж	ком	1	32,300,000.00	32,300,000.00
11	Хээрийн судалгааны ширээ	ш	1	270,000.00	270,000.00
12	Хээрийн судалгааны сандал	ш	5	272,000.00	1,360,000.00
13	Дээжний шкаф	ш	10	320,000.00	3,200,000.00
НИЙТ ДҮН			172		172,490,000.00
					(нэг зуун далан хоёр сая дөрвөн зуун ерэн мянган)